



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 47

Есөнбулаг сум

"Элэг бүтэн Алтай" аймгийн дэд
хөтөлбөр батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Элэг бүтэн Алтай" дэд хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөв, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган батлуулж, биелэлтийн явцыг жил бүрийн IV улиралд багтаан ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2017 оны 05 дугаар сарын 12-ны
өдрийн 42 дугаар тогтоолын
1-р хавсралт



“ЭЛЭГ БҮТЭН АЛТАЙ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Манай улс вируст гепатит өвчнийг 1952 оноос, А, В вируст гепатитийг 1981 оноос, С вируст гепатитийг 1998 оноос ялган оношилж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд D, E вируст гепатитийг ялган оношилж, улсын статистик мэдээнд бүртгэж эхэлсэн. Сүүлийн 50 жилийн хугацаанд (1960-2009) цочмог вируст гепатит өвчнөөр 536396 хүн өвчилсөн бөгөөд 1962 онд 28955 тохиолдол буюу 10000 хүн амд 331 тохиолдол байсан нь эпидемийн оргил үе байсан. В вируст гепатитийн эсрэг вакциныг 1991 оноос нэвтрүүлсний үр дүнд 5 хүртэлх насны хүүхдийн дунд HBsAg тээгчдийн тархалт 0,53 хувь болж ДЭМБ-ын дэвшүүлсэн зорилт (2 хувь)-ыг хангасан байна. А вируст гепатитийн эсрэг вакциныг 2012 оноос үе шаттайгаар нэвтрүүлснээр А вируст гепатитийн 10000 хүн амд ногдох тохиолдол 1,0 хувь болж, дархлаажуулалтын өмнөх үеэс 22 дахин буурсан болно. Элэгний хорт хавдрын 82.5 хувь нь хожуу буюу 3-4 дүгээр үе шатанд оношлогдож, хяналтад орсноос хойш 2,3 хувь нь 5-аас дээш жил амьдарч байна. Элэгний хорт хавдрын шалтгааны 46 хувь нь гепатитийн С вируст, 35 хувь нь В вируст, 14 хувь нь В, С вирусийн хавсарсан халдвартайг судлаачид тогтоосон байна. Одоогийн байдлаар нийт хүн амын дунд С вируст гепатитийн халдвар 10 хувь, В вируст гепатитийн халдвар 11,8 хувь, дельта вируст гепатитийн халдвар 4,8 хувийн тархалттай байна.


Манай аймагт сүүлийн 5 жилд нийт хавдрын нас баралт улсын дунджаас өндөр түвшинд байсан бөгөөд 2016 оны байдлаар улсын дунджаас доогуур үзүүлэлттэй байгаа боловч өмнөх онуудаас нэмэгдэж 16 пропромилль байна.




Элэгний хавраас шалтгаант нас баралт сүүлийн 5 жилд 5,5 пропромилль байсан бол өнгөрсөн 2016 онд 9,3 болсон нь улсын дунджаас 3,7 пропромилиэр өндөр байна.



Сүүлийн 5 жилийн байдлаар элэгний 635 шинэ өвчлөл бүртгэгдсэнээс 277 нь элэгний хорт хавдар байгаа нь элэгний өвчлөлийн 43.6 хувийг эзэлж байна.



Сүүлийн 5 жилд 277 элэгний хорт хавдар бүртгэгдсэнээс 85 буюу 30,6 хувь нь 1, 2 дугаар шатанд, 192 буюу 69,4 хувь нь 3,4 дүгээр шатанд оношлогдсон байна.



Өнгөрсөн жил манай аймагт 111 хорт хавдрын тохиолдол бүртгэгдснээс 53 буюу 47,7 хувийг элэгний хорт хавдар эзэлж байгаа бөгөөд, тэдгээрийн 30 нь эрэгтэй, 23 нь эмэгтэй хүн байна. Шинээр оношлогдсон хүмүүсийн 13 буюу 24,5 хувь нь 1,2-р шатандаа, 40 буюу 75,4 хувь нь 3,4-р шатандаа хожуу оношлогдсон. Хорт хавдраар нас барсан 108 хүний 55 буюу 50,9 хувь нь элэгний хорт хавдрын улмаас нас барсан байна.

Хожуу үедээ оношлогдож байгаагийн гол шалтгаан нь иргэдийн эрүүл мэндийн мэдлэг, боловсрол дутмаг, хөдөөгийн иргэд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагддаггүй, эрүүл мэнддээ тавих анхаарал сул байгаатай холбоотой.

Элэгний хорт хавдрын өвчлөл, нас баралт их байгаагийн үндсэн шалтгаан нь В,С вирусийн тархалт, архины хэт хэрэглээ, төрөл бүрийн шалтгаантай элэгний хатуурал, архаг үрэвсэл их байгаатай холбоотой юм. Элэгний анхдагч хорт хавдар нь ихэвчлэн шинж тэмдэггүйгээр хожуу үе шатандаа илэрдэг тул өвчний эрт үеийн оношилгоог сүүлийн үеийн багаж, тоног төхөөрөмжөөр оношлох шаардлагатай байдаг.

Хоёр. Хөтөлбөрийн уриа, зорилго, зорилт

2.1. Хөтөлбөрийн алсын хараа

“Элэгний хавдаргүй иргэний төлөө”

2.2. Хөтөлбөрийн зорилго

Говь-Алтай аймгийн хүн амын элэгний вирусийн халдварыг эрт илрүүлэх, эмчлэх, вирусийн халдварын тархалтыг хязгаарлах, вируст хепатитаас урьдчилан сэргийлэх, элэгний өвчлөл, түүнээс үүдэлтэй архаг үрэвсэл, цирроз, анхдагч хорт хавдрын шалтгаант нас баралтыг бууруулахад оршино.

2.3. Хөтөлбөрийн зорилт:

2.3.1. Элэгний хорт хавдартай тэмцэх, сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах

2.3.2. Хүн амыг вируст хепатитаас урьдчилан сэргийлэх, тэдний эрсдэлт зан үйлийг өөрчлөх, дархлаажуулалтыг өргөжүүлэх

2.3.3. Элэгний вирусийн халдварыг эрт илрүүлэх, эмчлэн хянах, чанартай, хүртээмжтэй тусламж үйлчилгээг үзүүлэх

2.3.4. Вируст хепатитийн халдвар, өвчлөл, элэгний анхдагч хорт хавдрыг эрт илрүүлэх, хянах, оношлох, хүн амын эрсдэлт зан үйлийг өөрчлөхөд салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх

Гурав. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1 Элэгний хорт хавдартай тэмцэх, сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах зорилтын хүрээнд:

3.1.1 Элэгний хорт хавдартай тэмцэх, сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсэг, ажиллах журам боловсруулж, санхүүгийн эх үүсвэрийг батлуулна;

3.1.2. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд эрт илрүүлгийн үзлэгт хамрагдах хүний судалгааг жил бүр шинэчлэн гаргана;

3.1.3. Эрүүл мэндийн төвүүдийн эмийн зардлын 10 хувийг эрт илрүүлгийн үзлэгийн хурдавчилсан оношлуур, багаж хэрэгсэлд зарцуулах тогтолцоог бий болгоно;

3.2 Хүн амыг вируст хепатитаас урьдчилан сэргийлэх, тэдний эрсдэлт зан үйлийг өөрчлөх, дархлаажуулалтыг өргөжүүлэх зорилтын хүрээнд:

3.2.1. Хүн ам, эрсдэлт бүлгийн вируст хепатитийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг нэгдсэн төлөвлөлтийн дагуу зохион байгуулна;

3.2.2. А вируст хепатитийн халдварын эсрэг вакцинаар бага насны хүүхдийг тархвар судлалын заалтаар дархлаажуулна;

3.2.3. Нярай хүүхдэд 24 цагийн дотор хийх В вируст хепатитийн халдварын эсрэг дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлнэ;

3.2.4. В вируст хепатитийн халдварын эсрэг дархлаажуулалтад сайн дураар хамрагдахыг олон нийтэд сурталчилж, хамрагдалтын тоог нэмэгдүүлнэ;

3.2.5. Хүүхдийн байгууллагын ариун цэвэр, эрүүл ахуйн стандартыг хангуулах, хүүхдийг гараа угаах дадал, хэвшилд сургах ажлыг зохион байгуулна.

3.3 Элэгний вирусийн халдварыг эрт илрүүлэх, эмчлэн хянах, чанартай, хүртээмжтэй тусламж үйлчилгээг үзүүлэх зорилтын хүрээнд:

3.3.1. 2017 онд 39-65 нас, 2018 онд 15-39 насны хүмүүсийг элэгний вирус илрүүлэх, баталгаажуулах шинжилгээнд хамруулна;

3.3.2 Вируст гепатитийн халдвар, түүний шалтгаант элэгний цирроз, хорт хавдрын оношилгоо, эмчилгээний тусламжийг чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ;

3.3.3.Жирэмсэн эмэгтэйчүүдийг В, С вируст гепатитийн халдварыг илрүүлэх шинжилгээнд бүрэн хамруулна;

3.3.4. Архаг гепатиттай өвчтөний өвчний үе шатыг үнэлэн эмчилж, хяналтанд авна;

3.3.5.Эрүүл мэндийн байгууллагуудыг лабораторийн болон дүрс оношилгооны орчин үеийн багаж, тоног төхөөрөмжөөр хангана;

3.3.6. Вируст гепатитийн оношилгоо, эмчилгээний чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй сургалтад хамруулан чадавхжуулна;

3.3.7. Вируст гепатиттай иргэнийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, хөнгөлттэй эм олгох асуудлыг холбогдох байгууллагатай хамтран үе шаттайгаар шийдвэрлэнэ.

3.4 Вируст гепатитийн халдвар, өвчлөл, элэгний анхдагч хорт хавдрыг эрт илрүүлэх, хянах, оношлох, хүн амын эрсдэлт зан үйлийг өөрчлөхөд салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

3.4.1. Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана;

3.4.2.Өсвөр үеийнхэн, оюутан залуусын дунд үе тэнгийн сургагч бэлтгэн тэднээр дамжуулан тогтмол сургалт явуулна;

3.4.3. Шивээс, гоо сайхны үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад халдваргүйжүүлэлтийн горимыг мөрдүүлэх үнэлгээг мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран хийх;

3.4.4.Эрүүл мэндийн байгууллагуудын халдварын хяналт сэргийлэлтийг тогтмол үнэлэх

3.4.5. Вируст гепатитаас урьдчилан сэргийлэх, эмчлэх чиглэлээр хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын санал, санаачилгыг дэмжиж, нөөц бололцоог нь дайчлан, үр дүнтэй хамтран ажиллана.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

4.1. Хөтөлбөрийг 2017-2021 онд хэрэгжүүлнэ. Эрт илрүүлгийг 2 үе шаттайгаар хийнэ.

4.2. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

4.2.1. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

4.2.2. эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгө;

4.2.3. олон улсын байгууллага, гадаад орны төсөл, хөтөлбөрийн хөрөнгө, хөнгөлөлттэй зээл, тусламж;

4.2.4. төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, хяналт, шинжилгээ

5.1 Эрүүл мэндийн газар улирал бүр хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад үнэлгээ хийнэ.

5.2 Нэгжүүдийн хэрэгжилтийн тайланг Эрүүл мэндийн газарт нэгтгэн жил бүрийн 1 дүгээр сард багтаан ИТХ, АЗДТГ-ын НБХ-т тайлагнана.

5.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн үнэлгээг хагас, бүтэн жилээр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хийнэ.

Зургаа. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлтийн тодорхойлолт	Суурь үзүүлэлт	Хүрэх түвшин			
	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Нийт хүн ам болон зорилтот бүлгийнхний дундах вируст гепатитын талаарх зөв зохистой мэдлэг, хандлагатай хүмүүсийн эзлэх хувь	15%	35%	45%	55 %	70%
Гепатитийн А вирусийн эсрэг вакцинжуулалтын хамралтын хүрээ	99.1%	99.4%	99.6 %	99.8 %	100%
Гепатитийн В вирусийн архаг халдварын 10-аас доош насны хүүхдүүдийн дундах тархалт	1.6%	1.4 %	1.2 %	1.0%	<1%
Гепатитын В вирусийн архаг халдварын 10-аас дээш 20-оос доош насны хүүхэд, залуучуудын дундах тархалт	-	<3%	<2.8 %	<2.4 %	<2%
Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, оюутнууд гепатитийн В вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралтын хувь	79.5%	80.5%	90.5%	95 %	100%
Цагдаа, цэрэг, онцгой байдлын ажилтнууд, зэрэг өндөр эрсдэлтэй бүлгүүдийг гепатитийн В вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралтын хувь	60%	70%	80%	90%	98%

Нярайг төрсний дараах 24 цагийн дотор хепатитийн В вирусийн эсрэг дархлаажуулалтад хамруулсан хувь	~98%	98.5%	99%	99.5%	100%
HBsAg, AntiHCV илрүүлэх шинжилгээнд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь	91,3%	93%	95%	98%	100 %
Хепатитийн В вирусийн архаг халдвартай эхээс урагт халдах халдварын хувь	-	28%	27%	28%	<25%
Халдварын сэргийлэлт хяналт үнэлгээнд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын хувь	60%	65%	70%	75%	80 %
Эмнэлгийн халдваргүйжүүлэлт ариутгалд хэрэглэгдэх шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр хангагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо	75%	80%	83%	85%	90%
Донорын цусанд хепатитийн В, С вирус илрүүлэх шинжилгээний хамралтын хувь	50%	60%	70%	80%	90%
Хепатитийн вирусийн халдвартай хүн амын дунд халдвартай гэдгээ мэддэг хүмүүсийн хувь	~25%	70%	80%	85%	90%
Хүн амыг хепатитийн В вирусийн халдвар тодорхойлох шинжилгээнд хамруулсан хувь	21%	70%	80%	90%	>95%
Хепатитийн В вирусийн халдвартай хүмүүсийг хепатитын Д вирусийн хам халдвар тодорхойлох шинжилгээнд хамруулсан хувь	5%	15%	30%	50%	>75%
Хүн амыг хепатитийн С вирусийн халдвар тодорхойлох шинжилгээнд хамруулсан хувь	21%	70%	80%	90%	>95%
Вирусийн халдвартай тохиолдлыг идэвхжил тодорхойлох шинжилгээнд хамруулсан хувь	30%	60%	70%	80%	90%
Эрт илрүүлэлтийн шинжилгээгээр хепатитийн вирусийн халдвартай гарсан хүмүүсийн оношийг баталгаажуулах шинжилгээнд хамруулсан хувь	30%	70%	80%	85%	>95%


Шинжилгээнд хамрагдсан бүх хүний шинжилгээний үр дүн үндэсний хэмжээнд нэгдсэн мэдээллийн санд тухайн хүний регистрийн дугаараар бүртгэгдэж урьдчилан сэргийлэх, эмчилгээнд хамруулах зэрэг олон талт үйл ажиллагааг тухайн хүний нөхцөлд тааруулан авч хэрэгжүүлэх боломжоор хангасан хувь	0%	70%	80%	90%	>95%
Хепатитийн вирусийн халдварыг баталгаажуулах, эмчилгээний явцад хяналт тавих тоон шинжилгээг чанарын өндөр түвшинд, нэгдсэн стандартын дагуу хийж гүйцэтгэхэд хэрэгцээтэй хуурай болон хүйтэн хэлхээний сорьц тээвэрлэлтийн тогтолцоог нэвтрүүлсэн байдал	45%	50%	60%	65%	>75%
Бүх шатлалын шинжилгээний лабораторийг дотоод болон гадаад хяналтанд хамруулсан хувь	5%	50%	60%	70%	>75%
Хепатитийн С вирусийн халдвартай эмчилгээнд хамруулах хэрэгтэй хүмүүсийн хувь	<0.5%	50%	65%	80%	>98%
Элэгний хорт хавдрын эрт үедээ илэрсэн хувь	26%	30%	40%	50%	60%
Хепатитийн В вирусийн дан халдвартай хүмүүсийг вирусийн идэвхжил дарангуйлах эмчилгээнд хамруулсан хувь	<0.5%	60%	75%	85%	>98%
Хепатитийн В, Д вирусийн хам халдвартай хүмүүс эмчилгээнд хамруулсан хувь	<0.5%	25%	35%	45%	>50%
Хепатитийн С вирусийн үүдэлтэй элэгний хатуурлын нас баралтыг бууруулсан хувь	-	25%	35%	45%	50%
Хепатитийн С вирусийн үүдэлтэй элэгний хорт хавдарын нас баралтыг бууруулсан хувь	-	35%	44%	45%	50%
Хепатитийн В вирусийн үүдэлтэй элэгний хатуурлын нас баралтыг бууруулсан хувь	-	5%	10%	15%	20%
Хепатитийн В вирусийн үүдэлтэй элэгний хорт хавдарын нас баралтыг бууруулсан хувь	-	5%	10%	15%	20%

Хяналт, оношилгоо, эмчилгээг хийх эмч, эмнэлгийн мэргэжилтний сургалтанд хамруулсан хувь	1.4%	50%	65%	80%	>90%
10000 хүн амд ногдох нийт вируст гепатитийн өвчлөл	1.9%	1,6%	1.2 %	0.8%	0.5%
Вирусийн хавсарсан халдвартай хүмүүсийн тоо, эзлэх хувь	-	15%	11%	8%	5%
Элэгний хавдраас шалтгаалсан нас баралтын тоо, эзлэх хувь	9.3%	7.5 %	6.8%	6.0 %	5.0%
Элэгний хатуурлаас шалтгаалсан нас баралтын тоо, эзлэх хувь	32 %	28%	25%	20%	15%

---o0o---



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2017 оны 05 дугаар сарын 05-ны
өдрийн 17 дугаар тогтоолын
2...-р хавсралт



“ЭЛЭГ БҮТЭН АЛТАЙ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	2017	2018	2019	2020	Санхүүжилт /сая төгрөгөөр/	Санхүүжилт-ийн эх үүсвэр
Нэг. Элэгний хорт хавдартай тэмцэх, сэргийлэх үйл ажиллагааны зохион байгуулалтыг боловсронгуй болгох										
1	“Элэг бүтэн Алтай” дэд хөтөлбөрийг хэлэлцүүлэн батлуулах	Хөтөлбөрийн хэлэлцүүлэг зохион байгуулж, хөтөлбөр батлагдсан байна.	Эрүүл мэндийн газар	Аймгийн ЗДТГ НБХ	+				-	
2	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулах	Ажлын хэсэг байгуулсан байна.	Эрүүл мэндийн газар	Аймгийн ЗДТГ НБХ	+				-	
3	Элэгний вирусийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдах хүмүүсийн бүртгэлийг жил бүр шинэчлэн гаргах	Хамрагдах хүмүүсийн бүртгэлийг шинэчлэн гаргасан байна	Эрүүл мэндийн газар	Сум, өрхийн эрүүл мэндийн төв	+	+	+	+	-	
Хоёр. Хүн амыг вируст гепатитаас урьдчилан сэргийлэх, тэдний эрсдэлт зан үйлийг өөрчлөх, дархлаажуулалтыг өргөжүүлэх										
1	Хүн амын вируст гепатитийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах	Сургалтанд хамрах хүрээний хүн амын 30 –аас доошгүй, сурталчилгаанд 70 хувийг хамруулсан байна.	Эрүүл мэндийн газар	Сум, өрхийн эрүүл мэндийн төв	+	+	+	+	12.000.0	УТ
2	Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрүүл мэндийн	Мэдээллийн хэрэгслээр	Эрүүл мэндийн газар	Орон нутгийн хэвлэл	+	+	+	+	1800.0	ОНХС

104

	боловсрол олгох сурталчилгааг тасралтгүй зохион байгуулах	явуулсан сурталчилгааны тоо		мэдээллийн газрууд						
3	Хүүхдийн байгууллагын нэг хүүхдэд ноогдох гар угаалтуурын тоог нэмэгдүүлэх саналыг боловсролын байгууллагад хүргүүлж, хүүхдүүдийг гар угаах аргад сургах ажлыг зохион байгуулах	Гар угаалтуурын тоо нэмэгдүүлсэн байгууллагын тоо, хүүхдүүдэд зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүүхдийн тоо	Эрүүл мэндийн газар	БСУГ СЭМТ ӨЭМТ	+	+	+	+	-	
4	Нярай хүүхдэд бүрт төрсний дараа 24 цагийн дотор хийх В вируст халдварын эсрэг дархлаажуулалт нэмэгдүүлэх	Дархлаажуулалтын хамрагдалтын хувь	НЭ СЭМТ	Эрүүл мэндийн газар	+	+	+	+	-	
5	В вирусийн халдварын эсрэг сайн дурын дархлаажуулалтыг иргэдэд сурталчилж, хамрагдалтыг нэмэгдүүлэх ажил зохион байгуулах	Сайн дурын дархлаажуулалтанд хамрагдсан иргэдийн тоо	СЭМТ ӨЭМТ	Эрүүл мэндийн газар	+	+	+	+	-	
Гурав. Элэгний вирусийн халдварыг эрт илрүүлэх, эмчлэн хянах, чанартай, хүртээмжтэй тусламж үйлчилгээг үзүүлэх										
1	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд хамруулах үзлэгийн хуваарийг нарийвчлан гаргах	Хуваарийн дагуу үзлэг зохион байгуулан хамрагдвал зохих хүний 90-ээс доошгүй хувийг хамруулсан байна.	СЭМТ ӨЭМТ	багийн дарга нар	+	+	+	+	-	
2	Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй нэн ядуу 40-65 насны иргэдийг даатгалд хамруулах	Даатгалд хамрагдсан иргэдийн тоо	СЭМТ ӨЭМТ	ЭМНДХ	+				5.184.0	ОНХС
3	Эрт илрүүлгийн оношилгооны багцын худалдан авалт, анхан шатны эрүүл мэндийн	Худалдан авалтын, тараалтын гэрээ хийгдсэн байна.	Нэгдсэн эмнэлэг	СЭМТ ӨЭМТ	+	+			80.423.0	ЭМД-ын сан

	байгууллагуудтай гэрээ хийх, хуваарилах									
4	Хамрагдвал зохих иргэдийн үзлэг, оношилгоо хийх	Хамрагдвал зохих иргэдийн 90-ээс доошгүй хувийг хамруулсан байна.	СЭМТ ӨЭМТ	Нэгдсэн эмнэлэг	+	+	+	+	-	
5	Вирус илэрсэн иргэдийн ийлдсийг идэвхжил тоолох шинжилгээнд илгээх	Идэвхжил тоолуулсан хувь	СЭМТ ӨЭМТ	Нэгдсэн эмнэлэг ЭМНДХ	+	+			185.396.0	ЭМД-ын сан
6	Вирусийн идэвхжил өндөртэй хүмүүсийг вирус дарангуйлах эмчилгээнд хамруулах	Эмчилгээнд хамрагдсан хүний тоо, эдгэрэлтийн хувь	Нэгдсэн эмнэлэг	ЭМНДХ	+	+			437.980.0	ЭМД-ын сан
7	Шинээр хяналтанд орсон жирэмсэн эхчүүдийг вирусийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулах	Хяналтанд орсон жирэмсэн эхийн вирусийн оношилгоонд хамрагдсан хувь	СЭМТ ӨЭМТ		+	+	+	+	11.200.0	УТ
8	Эрт илрүүлгийн шинжилгээнд хэрэглэгдэх эмнэлгийн хэрэгслээр хангах	Эмнэлгийн хэрэгслээр хангасан байгууллагын тоо	Эрүүл мэндийн газар	СЭМТ ӨЭМТ	+	+			4.424.2	ОНХС
9	Эрт илрүүлгийн шинжилгээний үзлэгийн хуудас, бүртгэлийн маягтаар хангах	Үзлэгийн хуудас, бүртгэлийн маягтаар хангах хангасан байгууллагын тоо	Эрүүл мэндийн газар	СЭМТ ӨЭМТ	+	+			6.172.3	ОНХС
Дөрөв. Вируст гепатитийн халдвар, өвчлөл, элэгний анхдагч хорт хавдрыг эрт илрүүлэх, хянах, оношлох, хүн амын эрсдэлт зан үйлийг өөрчлөхөд салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх										
1	Төр хувийн хэвшлийн байгууллагад ажилладаг эмч нарын мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, тэдэнтэй хамтран ажиллах	Сургалтанд хамрагдсан эмч, хамтран зохион байгуулсан үйл ажиллагаа,	Эрүүл мэндийн газар	Эмч орон тоогоор ажиллуулагч байгууллагууд	+	+	+	+		

		хамрагдсан хүний тоо								
2	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад халдварын сэргийлэлт, хяналтын үнэлгээ хийх	Үнэлгээнд хамрагдсан байгууллагын тоо, арилгасан зөрчлийн тоо	Эрүүл мэндийн газар	МХГ	+	+	+	+		
3	Өсвөр насныхан дундаас үе тэнгийн сургагч багш бэлтгэх, бага наснаас нь зөв зан үйлд сургах ажлыг зохион байгуулах;	10-аас доошгүй сургуульд үе тэнгийн сургагч хүүхдүүд бэлтгэгдсэн байна.	Эрүүл мэндийн газар	БСУГ Сум, өрхийн эрүүл мэндийн төв	+	+	+	+	2.000.0	УТ
4	Байгууллага бүрт эрүүл мэндийн сайн дурын зөвлөгч бэлтгэн албан хаагчдад эрүүл аж төрөх зөв хандлагын талаар мэдээлэл хүргүүлэх ажлыг хэвшүүлэх	Бэлтгэгдсэн сайн дурын зөвлөгчийн тоо	СЭМТ ӨЭМТ	Эрүүл мэндийн газар	+	+	+	+	-	
5	Эрт илрүүлгийн үзлэгийн зардлын санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сангаас шийдвэрлүүлэх	Шийдвэрлэсэн зардлын хэмжээ	ЭМНДХ НЭ	Эрүүл мэндийн газар	+	+	+	+	108.000.0	ЭМД-ын сан
6	Эрүүл мэндийн даатгалд хамрагдаж чадаагүй иргэний эрт илрүүлэг, эмчилгээний зардлыг шийдвэрлэх	Шийдвэрлэсэн зардлын хэмжээ	ЭМНДХ	ЭМНДХ	+	+	+	+	20.700.0	ОНХС
Нийт дүн									882.999.0	
Улсын төсвөөс										
Орон нутгийн төсвөөс										
Эрүүл мэндийн даатгалын сангаас										

107